

## СТЕП ГОЛД ХХК

### ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ БОДЛОГО

---

#### 1. Танилцуулга

Степ Голд ХХК ийн (“Степ” гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Степ нь компанийн захирлууд, гүйцэтгэх албан тушаалтнууд болон бусад Холбоотой этгээдүүд (“Төлөөлөгчид” гэх) –ийн үнэт цаасны тухай хууль, тогтоомжийн дагуу үнэт цаас арилжихад мөрдөх бодлогыг албан ёсоор гаргах шаардлагатай юм хэмээн тогтоолоо. Өөрөөр заагаагүй л бол, энэхүү Бодлогод хэрэглэгдсэн бүхий л тодорхой нэр томъёонууд нь Хавсралт “А”-д дурдсан утгатай байна. Энд хэрэглэгдсэнчлэн, “Степ” болон “Компани” гэдэгт Степ болон түүний салбар компаниудыг ойлгоно.

#### 2. Бодлогын зорилго

Нийтийн хүртээл болгоогүй дотоод мэдээллийн ангилалд байхад нь арилжаанд оруулах (Доорх 6.1 дахь хэсэгт тодорхойлсноор), болон бусдад уг нийтийн хүртээл болгоогүй дотоод мэдээллийг ил болгох нь үнэт цаасны болон эрүүгийн хуулийг зөрчсөн явдал болно. Энэхүү Үнэт цаасны арилжааны бодлогын (“Бодлого” гэх) зорилго нь (i) Компанийн Үнэт цаасыг арилжих, (ii) нийтийн хүртээл болоогүй дотоод материалыг танилцуулахад (Энэхүү Бодлогын 6.1 дахь хэсэгт дурдсанаар) шаардагдах удирдамж болон хязгаарлах нөхцлүүдээр хангана.

Энэхүү Бодлогод дурдсан удирдамж нь Компанийн Компанийн Ил тод байдлын бодлогод дурдсантай ижил байна.

#### 3. Бодлогын хэрэглээ

Энэхүү Бодлого нь Компанийн бүх Төлөөлөгчид болон Компанийн Үнэт цаасны (энэхүү Бодлогын Хавсралт “А”-д тодорхойлсноор компанийн хувьцаа, хөрвөх үнэт цаас, опцион болон бусад үнэт цааснууд орно) арилжаатай холбогдуулан аливаа Холбоотой этгээдүүдээс Нийтийн хүртээл болгоогүй дотоод мэдээллийг хүлээн авсан аливаа этгээдүүдэд хамаарна.

#### 4. Дүрмийг танилцуулах нь

Дүрмийн хуулбарыг компанид хамааралтай бүх этгээдүүдэд танилцуулна. Ингэхдээ Компанийн веб хуудас [www.steppegold.com](http://www.steppegold.com) дээр байрлуулна. Дүрмэнд тодорхой өөрчлөлтүүдийг хийсэн нөхцөлд Дүрмийг даган мөрдөх ёстой бүх Төлөөлөгчдөд мэдэгдэнэ. Шинэ Төлөөлөгч нарт энэ Дүрмийн хуулбарыг өгнө.

#### 5. Захиргааны хариуцлага

##### 5.1 Хяналтын албан тушаалтан

Энэхүү Бодлогын хувьд Гүйцэтгэх захирал нь хяналтын албан тушаалтны (“Хяналтын албан тушаалтан” гэх) үүргийг гүйцэтгэх ба, өдөр тутмын удирдлага, хяналтаар хангаж, Бодлогыг даган мөрдүүлнэ. Хяналтын албан тушаалтан нь энэхүү Бодлогын удирдлага, хяналтыг гүйцэтгүүлэхээд нэг ба түүнээс дээш тооны туслах ажилтнуудыг томилж болно.

## 6. Онцгой бодлогууд

### 6.1 Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээлэл

Компанийн Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээлэл бол **“Ерөнхийд нь нийтийн хүртээл болгосон”** ангилалд хамаарахгүй Дотоод мэдээлэл юм. Дараах төрлийн мэдээллийг “Ерөнхийд нь нийтийн хүртээл болгосон” ангилалд хамруулна. Үүнд:

- (a) хялбархан ажиглагдахуйц асуудлыг агуулсан мэдээлэл;
- (b) олон нийтэд мэдээлэлд дүн шинжилгээ хийх хангалттай цаг олгохын хамт хэвлэлийн мэдэгдэл гаргах замаар нийтийн хүртээл болгож болохуйц мэдээлэл; ба
- (c) мэдээллийн үлмаас үнэ нь буурч мэдэх Үнэт цаасанд хөрөнгө оруулсан этгээдүүдийн анхаарлыг татах, эсвэл татах магадлалтай байдлаар тодорхой хугацаагаар нийтийн хүртээл болсон мэдээлэл.

Хугацаа нь арай урт, эсвэл богино байж болох юм хэмээн зөвлөөгүй л бол, 6.1 (b)8 6.1 (c) догол мөрнүүдийн үлмаас, Нийтийн хүртээл болгоогүй дотоод мэдээллийг Ерөнхийд нь нийтийн хүртээл болгосны дараа, Торонтогийн Хөрөнгийн Биржийн арилжаа нээгдсэнээс хойш 2 дахь өдөр нь бизнес дуусгавар болоход үндэслэлтэй дүн болон үндэслэлтэй хугацаа дуусах болно.

Стептэй холбоотой Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг мэддэг аливаа этгээд, уг Дотоод мэдээллийг Ерөнхийд нь Нийтийн хүртээл болготол уг мэдээллийг нууцлалын зэрэгтэй мэдээлэлд тооцох ёстой. Нууцлалын зэрэгтэй мэдээлэлтэй хэрхэн харьцах талаар Компанийн “Компанийн Ил тодын бодлого” –оос үзнэ үү.

Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг “бизнесийн чухал шаардлага” -аас (энэ Бодлогын 6.3 дахь хэсэгт тодорхойлсноор) бусад тохиолдолд хэнд ч ил болгож болохгүй. Хэрэв Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг “бизнесийн чухал шаардлагаар” хуулийн дагуу нийтийн хүртээл болгосон бол, мэдээллийг ийм байдлаар хүлээн авсан хэн бүхэн уг мэдээллийг нууцлалын зэрэгтэй мэдээлэл гэж тооцох бөгөөд, боломжтой бол нууцлалын гэрээ байгуулан ажиллана.

Хэрэв мэдээллийг нийтийн хүртээл болгох гэж байгаа хүн уг Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг дэлгэх гэж байгаа хүн нь дараах үйлдлийг хийх гэж байгааг нь мэдсэн, эсвэл мэдсэн байх үндэслэлтэй бол, Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг ямар ч тохиолдолд, бизнесийн чухал шаардлага гарсан ч гэсэн нийтийн хүртээл болгож болохгүй. Дараах үйлдэл гэдэг нь:

- Үнэт цаасыг авах хүсэлт гаргах, авах, захиран зарцуулах, эсвэл Үнэт цаасыг авах хүсэлт гаргах, авах, захиран зарцуулах зорилгоор гэрээ байгуулах; эсвэл
- Өөр нэгэн этгээдийг үнэт цаасыг авах хүсэлт гаргах, авах, захиран зарцуулахад зуучлах, эсвэл Үнэт цаасыг авах хүсэлт гаргах, авах, захиран зарцуулах зорилгоор гэрээ байгуулахад зуучлах зэрэг үйлдэл багтана.

Аливаа эргэлзээтэй асуудал гарсан тохиолдолд, энэхүү Бодлого хамаарах бүх этгээдүүд дараах зүйлсийг тодорхой болгох үүднээс Хяналтын албан тушаалтантай зөвлөлдөх ёстой:

- Тодорхой нөхцөлд мэдээллийг нийтийн хүртээл болгох нөхцөл гэдэгт бизнесийн чухал шаардлага гарах гэсэн нөхцөл багтах эсэх; ба
- мэдээллийг нийтийн хүртээл болгох гэж байгаа хүн уг Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг дэлгэх гэж байгаа хүн нь Үнэт цаасыг авах хүсэлт гаргах, авах, захиран зарцуулах, эсвэл Үнэт цаасыг авах хүсэлт гаргах, авах, захиран зарцуулах зорилгоор гэрээ байгуулах; эсвэл Өөр нэгэн этгээдийг үнэт цаасыг авах хүсэлт гаргах, авах, захиран зарцуулахад зуучлах, эсвэл Үнэт цаасыг авах хүсэлт гаргах, авах, захиран зарцуулах зорилгоор гэрээ байгуулахад зуучлах гэж байгааг нь мэдсэн эсэх.

Илүү тодорхой болгох үүднээс, шинжээчид, хөрөнгө оруулагч байгууллагууд, бусад зэх зээлийн мэргэжилтнүүд ба хэвлэл мэдээллийнхэн мэдээллийг нийтийн хүртээл болгох үйлдэл бол “Типпинг” (буюу олон нийтэд үнэт цаас арилжаалдаг компанийн тухай Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг мэдээлэл авах эрхгүй этгээдэд задруулах үйлдэл.орч) – ийн нэг хэлбэр (энэ Бодлогын 6.3 дахь хэсэгт тодорхойлсноор) бөгөөд үүнийг бизнесийн чухал шаардлага гэж үзэхгүй.

## 6.2 *Компанийн үнэт цаасыг арилжаалах нь*

Энэхүү Бодлогын улмаас, Дотоод Арилжаа гэдгийг Стептэй “Онцгой харилцаа” –тай (“Холбогдох этгээд”) эсэхээс үл хамааран Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг мэддэг аль нэг этгээдийн зүгээс Үнэт цаасыг худалдах, худалдан авах ажиллагаа гэж ойлгоно. Холбогдох этгээдийн арилжаа нь хууль бус бөгөөд энэ Бодлогын дагуу бол хориотой зүйл юм. Илүү тодорхой болгох үүднээс, ийм этгээдийн хориотой үйлдлийн жишээг доор үзүүлэв. Гэхдээ хориотой үйлдэл нь зөвхөн эдгээрээр үл хязгаарлагдана.:

- (a) Компанийн Үнэт цаасыг худалдан авах, худалдах;
- (b) Компанийн Үнэт цаасны үнэд гарсан өөрчлөлтийн улмаас үнэ, үнэлгээнд нь сөргөөр нөлөөлөх Үнэт цаасыг худалдан авах, худалдах;
- (a) Хувьцааны сонголт буюу хувьцааг тогтсон үнээр тогтоосон хугацааны эцэст худалдах авах эрхийг хэрэгжүүлэх замаар олж авсан Үнэт цаасыг худалдах; ба
- (b) Компанийн хөрөнгө оруулахаар төлөвлөж байгаа, эсвэл аль нэг хувь хүн Степт ажиллаж байх хугацаандаа, тухайн компанитай холбоотой Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг мэддэг болсон тэр компанийн Үнэт цаасыг худалдан авах, худалдах.

## 6.3 *Типпинг / олон нийтэд үнэт цаас арилжаалдаг компанийн тухай Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг мэдээлэл авах эрхгүй этгээдэд задруулах үйлдэл /*

Үнэт цаас гаргагчийн хувиар Степ ба/эсвэл Холбогдох этгээд болох аливаа этгээд эсвэл компаниас, бизнесийн чухал шаардлага эсвэл зөвхөн тодорхой нөхцлүүдээс бусад нөхцөлд, Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг нийтийн хүртээл болгосон үйлдлийг типпинг

гэнэ. Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг илүү өргөн хүрээнд, хөрөнгө оруулагч олон нийтийн хүрээнд бус зөвхөн цөөн тооны гарт өгч байгаа учраас Типпинг хэмээх энэ үйлдэл нь хориотой байдаг.

Доор хэлэлцсэн тодорхой хязгаарлалтуудын дагуу, хэрэв бизнесийн чухал шаардлагаар мэдээллийг сонголтоор нийтийн хүртээл болгох шаардлага гарвал, Типпингийг хориглох заалтыг үл хамаарах тохиолдол бий.

Тодорхой нийтийн хүртээл болгох ажиллагаа нь “бизнесийн чухал шаардлагаар” хийгдэж байгаа эсэх нь нэлээд эргэлзээтэй асуудал учраас нэг бүрчлэн нарийн хянах ёстой. Гэхдээ, бизнесийн чухал шаардлагуудын тохиолдол гэдэг нь ерөнхийдөө дараах этгээдүүдтэй холбогдох харилцааг хамардаг. Үүнд:

- (a) Судалгаа, хөгжүүлэлт, борлуулалт, маркетинг, нийлүүлэлтийн гэрээ гэх зэрэг асуудлаар худалдаачид, нийлүүлэгчид болон стратегийн түншүүд;
- (b) Ажилчид, албан тушаалтнууд болон зөвлөлийн гишүүд;
- (c) Стептэй хамааралтай Зээлдэгчид, хуулийн зөвлөх, аудиторууд, андерайтерүүд ба санхүүгийн болон бусад мэргэжлийн зөвлөхүүд;
- (d) Гэрээ хэлцэл хийж буй талууд;
- (e) Үйлдвэрчний эвлэлүүд ба аж үйлдвэрийн нэгдлүүд;
- (f) Төрийн байгууллагууд ба төрийн бус зохицуулагчид; болон
- (g) Зээлийн үнэлгээний агентлагууд (зээлийн үнэлгээг гаргах зорилгоор мэдээллийг агентлагт нийтийн хүртээл болгосон бол),

(хамтад нь “**Нийтийн хүртээл болгохгүй тохиолдол**”).

Гэхдээ, дээр дурдсанчлан, мэдээллийг дэлгэх гэж буй этгээд нь хэрэв мэдээллийг хүлээн авах тал нь дараах үйлдлийг хийх гэж байгааг мэдсэн, эсвэл мэдсэн байх үндэслэлтэй нөхцөлд Типпинг-д хамаарахгүй энэ тохиолдол үйлчлэхгүй.

Дараах үйлдэл гэдэг нь:

- Үнэт цаасыг авах хүсэлт гаргах, авах, захиран зарцуулах, эсвэл Үнэт цаасыг авах хүсэлт гаргах, авах, захиран зарцуулах зорилгоор гэрээ байгуулах; эсвэл
- Өөр нэгэн этгээдийг үнэт цаасыг авах хүсэлт гаргах, авах, захиран зарцуулахад зуучлах, эсвэл Үнэт цаасыг авах хүсэлт гаргах, авах, захиран зарцуулах зорилгоор гэрээ байгуулахад зуучлах зэрэг үйлдэл багтана.

6.4 *Холбоотой этгээдийн арилжааны тайлан – Канадын үнэт цаасны тухай хуулийн шаардлагууд*

Канадын үнэт цаасны тухай хууль тогтоомжийн дагуу, Компанийн “Тайлагнах үүрэг бүхий этгээдүүд” гэгдэх Холбоотой этгээдүүд [www.sedi.ca](http://www.sedi.ca) веб хуудас дахь “Холбоотой этгээдүүдийн

цахимаар мэдээлэл ил болгох систем” (“SEDI” гэх) –ээр цахимаар Тайлагнах үүрэг бүхий этгээдүүд болсноос хойш арав (10) хоногийн дотор эхний холбоотой этгээдийн арилжааны тайланг бүртгүүлэх шаардлагатай.

Тайлагнах үүрэг бүхий этгээдүүд (i) шууд болон шууд бусаар Компанийн Үнэт цаасны эзэмшил, хяналт, удирдлага, (ii) Компанийн Үнэт цаасыг хамарсан Холбоотой Санхүүгийн Хэрэгсэлд холбогдох эрх, үүрэгт өөрчлөлт гарсанаас хойш таван /5/ хоногийн дотор SEDI дээр холбоотой этгээдийн тайланг бүртгүүлэх шаардлагатай.

Тайлагнах үүрэг бүхий этгээдүүд мөн хэрэв Тайлагнах үүрэг бүхий этгээд (i) шууд болон шууд бусаар Тайлагнах үүрэг бүхий этгээдийн Степд хамаарах эдийн засгийн эрсдлийг өөрчлөх үр дүн бүхий, (ii) шууд болон шууд бусаар, Компанийн Үнэт цаас эсвэл Компанийн үнэт цаасыг хамарсан Холбоотой Санхүүгийн хэрэгсэлийг хамарсан гэрээн байгуулсан, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан, гэрээг дуусгавар болгосон бол, холбоотой этгээдийн тайланг таван /5/ хоногийн дотор бүртгүүлэх ёстой.

Тайлагнах үүрэг бүхий этгээд бүр өөрсдийн SEDI профайлыг үүсгэж, хөтлөн, шаардлагатай бүртгэлийг хийх үүрэгтэй. Гэхдээ, холбогдох этгээдүүд шаардлагатай мэдээллүүдээ Хяналтын албан тушаалтанд цаг тухайд нь өгсөн тохиолдолд Компанийн зүгээс иймэрхүү бүртгэл, хөтлөлтөө хийхэд нь Тайлагнах үүрэг бүхий этгээдүүдэд туслаж болно.

Өөрийгөө Тайлагнах үүрэг бүхий этгээд мөн эсэх, эсвэл эдгээр шаардлагуудаас чөлөөлөгдөх эрхтэй эсэхээ сайн мэдэхгүй байгаа хүн Хяналтын албан тушаалтанд хандах хэрэгтэй.

## 7. Удирдамж

7.1 Төлөөлөгчдийн хувьд ямар ч Арилжааны бус үе, Арилжааг түр зогсоох хугацаа гэж байхгүй

Төлөөлөгчид тухайн улирлын болон жилийн эцсийн санхүүгийн таамагласан үр дүнгийн талаарх нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг эзэмшиж байж болох учраас **санхүүгийн үр дүнг урьдчилсан байдлаар гаргахаас 15 хоногийн өмнө** эхэлж, тухайн улирлын /эсвэл жилийн/ /”Арилжааны бус үе”/ санхүүгийн тайланг олон нийтэд дэлгэсэн өдрөөс хойш Арилжааны нэг өдрийн дараа дуусах хугацаа нь нэлээд нууцлаг байдаг.

Тиймээс, энэхүү Бодлого болон холбогдох үнэт цаасны тухай хуулиудыг даган мөрдөх үүднээс, Арилжааны бус үеийн түршид Төлөөлөгчид Компанийн Үнэт цааснуудыг хамарсан аливаа арилжааны үйл ажиллагааг явуулахаас түдгэлзэнэ.

Степ, цаашид, Нийтийн хүртээл болоогүй Дотоод мэдээлэлтэй холбогдуулан Төлөөлөгчид болон бусад этгээдүүдийн хувьд арилжааг хязгаарлан нэмэлт хугацааг (“**Арилжааг түр зогсоох хугацаа**”) тогтоож болно. Арилжааг түр зогсоох хугацаа болон Арилжааны бус үеийг тогтоосон нөхцөлд, Хяналтын албан тушаалтан, хүмүүст арилжааг түр зогсооход хүргэсэн баримт шалтгааныг дурдалгүйгээр, дараачийн мэдэгдэл гартал Компанийн Үнэт цаасны ямар ч арилжаанд оролцохгүй байхыг зөвлөж, Компанийн Үнэт цаасны арилжааг түр зогсоох мэдэгдлийг Хавсралт “С” буюу “В”-д хавсаргасан маягтаар эсвэл батлагдсан өөр маягтаар гарган, түгээнэ.

Арилжааг түр зогсоох хугацаа болон Арилжааны бус үеийн алинд нь ч хамаарахгүй үед хүртэл Компанийн талаарх Нийтэд дэлгээгүй дотоод мэдээллийг эзэмшиж буй аливаа этгээд тухайн мэдээллийг нийтэд дэлгэснээс хойш хоёр Арилжааны өдөр өнгөртөл Компанийн Үнэт цаастай холбоотой аливаа үйл ажиллагаанд оролцохгүй. Бүх Төлөөлөгчид болон бусад этгээдүүд энэхүү Бодлогыг тайлбарлахдаа өөрийн санал бодолд тулгуурлан, сэрэмжтэй байх хандлага гаргаж болно. Хэрэв эргэлзэж байвал, тухайн этгээд Хяналтын албан тушаалтантай холбогдох шаардлагатай.

Тодорхой хугацаанд, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл Компанийн Хувьцааны Опционы төлөвлөгөөний хүрээнд урт хугацаат нөхөн олговрыг олгож болно. Гэхдээ Арилжааны бус үе болон Арилжааг түр зогсоох хугацаа хүчин төгөлдөр байгаа үед ямар ч нөхцөлд Компанийн Үнэт цаастай холбоотой урт хугацаат нөхөн олговрыг олгож болохгүй. Хэрэв Арилжааны бус үе болон Арилжааг түр зогсоох хугацаанд опционууд болон урт хугацаат нөхөн олговортой холбоотой бусад Үнэт цаасны хугацаа дуусвал, Компанийн Урамшууллын Хувьцааны Опционы Төлөвлөгөөнд, эсвэл үнэт цаасны нөхөн олговрын асуудлыг зохицуулдаг бусад төлөвлөгөөнд зааснаар сунгана.

#### *7.2 Арилжааны урьдчилсан зөвшөөрөл*

Компанийн Үнэт цаасанд аливаа арилжааг эхлүүлэхээс өмнө, энэ Бодлого хамаарах хэн бүхэн Хяналтын албан тушаалтантай холбоо барьж, зөвшөөрөл авах ёстой. Төлөвлөсөн хэлцэл нь холбоотой этгээдтэй холбоотой арилжааны асуудал эсвэл үнэт цаасны тухай хууль тогтоомжтой холбоотой асуудлуудыг үүсгэж болох эсэхийг тогтоох зорилгоор хэлцэл бүрийг үнэлнэ. Хэлцлийн зөвшөөрөл нь зөвхөн 48 цагийн хугацаанд хүчинтэй байна. Хэрэв хэлцлийн даалгаврыг 48 цагийн дотор гаргахгүй бол, төлөвлөсөн хэлцлийн зөвшөөрлийг дахин хүсэх ёстой болно. Хэрэв зөвшөөрлийн хүсэлтийг татгалзвал, зөвшөөрөл хүссэн этгээд ийнхүү татгалзсан тухай баримтыг нууцлалтайгаар хадгална.

#### *7.3 Short-Swing Арилжаа*

Компанийн зүгээс Төлөөлөгчдөд зургаан сарын хугацаанд өөрийн Үнэт цааснаас худалдах, худалдан авах ямар нэгэн ажиллагаа хийхгүй байхыг санал болгодог.

#### *7.4 Богино хугацаат худалдаа, Худалдах опцион ба худалдаж авах опцион*

Төлөөлөгчдөд Компанийн Үнэт цаасан дээр “богино” эсвэл “худалдах опцион” – ийг худалдах, “худалдаж авах опцион”-ыг худалдаж авахыг зөвшөөрдөггүй.

#### *7.5 Компанийн Үнэт цаасыг барьцааны илүүдлээр худалдаж авах нь*

Компанийн үнэт цаасыг барьцааны илүүдлээр буюу үнэт цаасыг өөрөөр нь барьцаа болгон брокороос зээлсэн мөнгөөр худалдаж авахыг Төлөөлөгчдөд зөвшөөрдөггүй.

#### *7.6 Хамгаалалт – Үнийн тааламжгүй өөрчлөлтийн эрсдлээс хамгаалах нь*

Компанийн захирлууд болон албан тушаалтнууд болсон Төлөөлөгчдөд Компанийн Үнэт цаастай холбогдох тухайн холбоотой этгээдийн аливаа шууд бус ашиг сонирхлын эдийн засгийн үнэлгээг тэнцүүлэх үр дүн бүхий аливаа хэлцэлд оролцохыг зөвшөөрдөггүй. Үүнд тухайн холбоотой этгээдэд нөхөн олговроор олгосон, эсвэл тухайн Холбоотой этгээдийн шууд болон шууд бусаар

эзэмшдэг Үнэт цаасны зах зээлийн үнийг хамгаалах, эсвэл тэнцүүлэх зорилго бүхий урьдчилж төлсөн хувьсах форвард гэрээ, хувьцааны своп гэх мэт санхүүгийн хэрэгслүүдийг худалдан авах ажиллагаа багтана.

## **8. Болзошгүй эрүүгийн болон захиргааны хариуцлага / Сахилгын арга хэмжээ**

### **8.1 Холбоотой этгээдийн арилжаанд хүлээлгэх хариуцлага – Канадад**

Канадын үнэт цаасны тухай хуулийн дагуу, Компанийн Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг арилжсан бүрүүтэй Төлөөлөгчдөд дараах хариуцлага, шийтгэл оногдуулна. Үүнд:

- (a) 5 сая хүртэл долларын торгууль ба олсон орлого болон сэргийлсэн алдагдлыг гурав дахин нэмэгдүүлсэн дүнтэй тэнцэх торгууль; ба
- (b) Хорих ял.

Мөн түүнчлэн, ийм үйлдэл нь Компанийн эсвэл бусад хөөрнгө оруулагчдад захиргааны хариуцлага хүлээлгэх үндэслэл болж болно.

### **8.2 Типпинг зохион байгуулсны төлөө хүлээлгэх хариуцлага – Канадад**

Төлөөлөгчдийн зүгээс Компанийн талаарх Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг ил болгосон, мөн тухайн мэдээлэлд суурилан Төлөөлөгчдийн зүгээс ямар нэгэн зүйл санал болгож, саналаа илэрхийлсэн хэн нэгний үйлдсэн зохисгүй хэлцлийн хариуцлагыг Төлөөлөгчид хүлээнэ. Хэдийгээр мэдээлэл задруулсан этгээд нь арилжаанаас ямар ч ашиг олоогүй ч гэлээ Канадын Үнэт цаасны зохицуулагч байгууллагаас ихээхэн хэмжээний торгууль оногдуулна.

### **8.3 Болзошгүй сахилгын арга хэмжээ**

Энэхүү Бодлогыг зөрчсөн Төлөөлөгчдөд Компанийн зүгээс сахилгын арга хэмжээ авна. Энэ нь ирээдүйн урамшууллын төлөвлөгөөнд оролцоход нь хориг тавих, эсвэл хөдөлмөр эрхлэлтийг нь цуцлах хүртэл арга хэмжээ байж болно.

## **9. Бусад компанитай холбогдох Холбоотой этгээдийн мэдээллэлд уг бодлого хэрхэн нөлөөлөх талаар**

Энэхүү Бодлого болон энд тодорхойлогдсон удирдамжууд нь хамтарсан компани, үйлчлүүлэгчид, Компанийн түншүүд, нийлүүлэгчид гэх мэт бусад компаниудтай (**“Бизнесийн түншүүд”** гэх) холбогдох Нийтийн хүртээл болоогүй Дотоод мэдээлэлд хамаарна. Энэхүү Бодлогын зорилгын улмаас, Бизнесийн түншүүдийн талаарх мэдээллийг Степт шууд хамааралтай мэдээллийн нэгэн адил авч үзнэ.

## **10. Даган мөрдөх тухай баталгаа**

Компанийн бүх захирал, албан тушаалтан нь Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтоосон бүх Төлөөлөгч нарын хамт Компанийн Бизнесийн ёс зүйн дүрэмд хавсаргасан маягтаар энэхүү Дүрмийг даган мөрдөх тухай баталгааг гарган өгнө.

## **11. Ерөнхий**

Зөвлөлөөс, цаашид, энэхүү Холбоотой Этгээдийн Арилжааны Бодлогын нөхцлөөс татгалзахыг зөвшөөрч болно. Энэхүү Холбоотой Этгээдийн Арилжааны Бодлогын нөхцлүүд нь Степт болон түүний Төлөөлөгч нарт, аливаа хувьцаа эзэмшигч, үнэт цаас эзэмшигч, үйлчлүүлэгч, нийлүүлэгч, өрсөлдөгч, бусад ажилчид ба зохицуулагчид гэх мэт аливаа гуравдагч этгээдэд иргэний хариуцлага хүлээлгэх зорилготой биш боловч Степт хариуцлага хүлээлгэх үндэс болно.

Хамгийн сүүлд батласан огноо:: 2017 оны 10 сарын 2

Баталсан: Компанийн засаглал ба Нэр дэвшүүлэх хороо  
Төлөөлөн Удирдах Зөвлөл



## ХАВСРАЛТ “А”

### ЭНЭХҮҮ БОДЛОГО ХАМААРАХ ХУВЬ ХҮМҮҮС БА БАЙГУУЛЛАГУУД

“Ажилчин” гэдэг нь Компанийн үндсэн болон цагийн ажилчин, эсвэл гэрээт болон түр ажилтыг хэлнэ.

“Холбоотой этгээд” гэдэг нь:

- (a) нийтийн хүртээл болоогүй Дотоод мэдээллийг (6.1 дахь хэсэгт тодорхойлсноор) хүлээн авдаг эсвэл тэдгээр мэдээлэлд нэвтрэх боломжтой Компанийн бүхий л захирлууд, албан тушаалтнууд, ажилчид, гүйцэтгэгч болон зөвлөхүүдийг хэлнэ. Мөн уг тодорхойлолтод тэдний хамгийн ойрын гэр бүлийн гишүүд, түншүүд, итгэмжлэгдсэн этгээдүүд, корпорацитууд, болон тэдгээр хувь хүмүүс хяналт, удирдлагыг нь хэрэгжүүлдэг бусад ижил төстэй байгууллагууд багтана;
- (b) Компанийн салбарын Холбоотой этгээд, захирал, албан тушаалтан, эсвэл бусад этгээд;
- (c) Дараах хамаарал, эзэмшил бүхий этгээд, компани
  - (i) эзэмшлийн хувийг тооцоолох үүднээс үнэт цаасыг хуваарилах явцад андеррайтер байдлаар эзэмшдэг аливаа Үнэт цааснаас бусад Компанийн саналын эрхтэй хувьцаанаас 10-аас дээш хувийг эзэмшдэг, шууд ба шууд бусаар үр ашиг хүртдэг, удирдан чиглүүлдэг, эсвэл
  - (ii) эзэмшлийн хувийг тооцоолох үүднээс үнэт цаасыг хуваарилах явцад андеррайтер байдлаар эзэмшдэг аливаа Үнэт цааснаас бусад Компанийн бүхий л төлөгдөөгүй саналын эрхтэй Үнэт цааснуудад хамааралтай саналын эрхийн 10-аас дээш хувийг эзэмшдэг, шууд ба шууд бусаар үр ашиг хүртдэг, удирдан чиглүүлдэг;
- (d) Хэрэв Степ өөрийн гаргасан Үнэт цаасыг худалдан авсан, эргүүлэн авсан, эсвэл өөр ямар нэгэн байдлаар олж авсан бол, Степ өөрөө;
- (e) Онтариогийн Үнэт цаасны тухай хуулийн 1(11) хэсгийн дагуу Холбоотой этгээдээр томилогдсон аль нэг этгээд эсвэл компани; ба
- (f) Онтариогийн Үнэт цаасны тухай хуулийн 143(1) дахь дэд хэсгийн 40v – параграфын дагуу томилогдсон бүлэгт багтах аль нэг этгээд эсвэл компани.

“Томоохон салбар компани” гэдэг нь үнэт цаас гаргагчийн хамгийн сүүлийн жилийн эцсийн аудитлагдсан эсвэл завсрын тайлан балансад тусгагдсанаар, эсвэл 2011 оны 1 сарын 1-ний өдөр, эсвэл түүнээс хойш эхлэх санхүүгийн жилд хамаарах хугацааны туршид, хэрэв салбар компанийн хөрөнгө нь тухайн тайлан балансад эсвэл санхүүгийн байдлын мэдэгдэлд тусгагдсанаар үнэт цаас гаргагчийн нэгдсэн хөрөнгийн 30 хувь ба түүнээс дээш хувийг эзэлдэг бол хувьцаа гаргасан компани, эсвэл салбар компанийн орлого нь, үнэт цаас гаргагчийн хамгийн сүүлийн жилийн эцсийн аудитлагдсан эсвэл завсрын орлогын тайланд тусгагдсанаар,

эсвэл 2011 оны 1 сарын 1-ний өдөр, эсвэл түүнээс хойш эхлэх санхүүгийн жилд хамаарах хугацааны туршид, нэгдсэн орлогын тайланд тусгагдсанаар үнэт цаас гаргагчийн нэгдсэн орлогын 30 хувь ба түүнээс дээш хувийг эзэлдэг бол тухайн үнэт цаас гаргагч.

**“Менежемэнтийн компани”** гэдэг нь үнэт цаас гаргагч компани, эсвэл үнэт цаас гаргагчийн салбарт ач холбогдол бүхий менежмент, удирдлагын үйлчилгээ үзүүлдэг этгээд, эсвэл компани;

**“Албан тушаалтан”** гэдэг нь:

- (a) Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, дэд дарга, Гүйцэтгэх захирал, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Ерөнхий санхүүч, Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, нарийн бичгийн дарга, нарийн бичгийн даргын туслах, нярав, туслах нярав ба ерөнхий менежер;
- (b) Дүрмийн дагуу эсвэл ижил төстэй журмын дагуу албан тушаалтнаар томилогдсон хувь хүн, ба
- (c) Дээр дурдсан хувь хүний ажил үүрэгтэй ижил төстэй ажил үүргийг гүйцэтгэдэг хувь хүн.

**“Үнэт цаас гаргагчтай онцгой харилцаа бүхий этгээд эсвэл компани”** гэдэг нь:

- (a) Дараах этгээдүүдийн Холбоотой этгээд, охин компани, салбар, хамтрагч болсон этгээд эсвэл компани,
  - (i) Степ,
  - (ii) Компанийн Үнэт цаасыг, Онтариогийн Үнэт цаасны тухай хуулийн XX хэсэгт заасанчлан, хүчээр худалдан авахаар санаархаж буй, санал болгож буй, эсвэл ийм зорилгоор төлөвлөгөө гаргаж буй этгээд эсвэл компани, эсвэл
  - (iii) Компанийн өмчөөс нэлээд их хувийг авахын тулд компанийн өөрчлөн байгуулалт, нэгдэл, нийлэлт ба ижил төстэй бизнесийн холбоо нэгдэлд орохоор санаархаж буй, санал болгож буй, эсвэл ийм зорилгоор төлөвлөгөө гаргаж буй этгээд эсвэл компани,
- (b) Стептэй хамтран, эсвэл түүнийг төлөөлөн, эсвэл (a) хэсгийн (ii), (iii) –т тодорхойлсон этгээд, эсвэл компанитай, эсвэл түүнийг төлөөлөн, аливаа бизнес эсвэл мэргэжлийн үйл ажиллагаанд оролцож байгаа, оролцохоор санаархаж байгаа, оролцох зорилгоор төлөвлөгөө гаргаж байгаа этгээд эсвэл компани,
- (c) Компанийн захирал, албан тушаалтан эсвэл аижлтан, Компанийн салбар, эсвэл Степийг, эсвэл (a) хэсгийн (ii), (iii) ба (b) хэсэгт тодорхойлсон этгээд, эсвэл компанийг, шууд болон шууд бусаар, хянадаг этгээд эсвэл компани,
- (d) Дээрх (a), (b), (c) зүйлүүдэд тодорхойлсон этгээд эсвэл компанийн холбогдох этгээд байхдаа Стептэй холбогдуулан бодит баримт, эсвэл чухал өөрчлөлтийн талаар олж мэдсэн этгээд, эсвэл компани,

- (e) Энэ зүйлд тодорхойлсон этгээд эсвэл компанийг оруулж энэхүү дэд хэсэгт тодорхойлсон аливаа бусад этгээд эсвэл компаниас Стептэй холбогдуулан бодит баримт, эсвэл чухал өөрчлөлтийн талаар олж мэдсэн, эсвэл бусад этгээд эсвэл компани нь ийм харилцаатай этгээд эсвэл компани болохыг мэддэг, эсвэл мэддэг байх үндэслэлтэй этгээд, эсвэл компани.

**“Холбогдох санхүүгийн хэрэгсэл”** гэдэг нь Компанийн аль нэг Холбоотой этгээд нэг тал нь болсон, түүний үр дүн нь, шууд болон шууд бусаар, Холбоотой этгээдий дараах зүйлсийг өөрчлөх, аливаа гэрээ, хэлцэл, тохиролцоо, харилцан ойлголцлыг хэлнэ. Дараах зүйлс гэдэгт,

- (a) Компанийн Үнэт цаасанд хамаарах эдийн засгийн сонирхол, эсвэл
- (b) Степт учрах эдийн засгийн эрсдэл.

**“Тайлагнах үүрэг бүхий этгээд”** гэдэг нь хэрэв Холбоотой этгээд нь дараах этгээд мөн бол Компанийн аль нэг Холбоотой этгээдийг хэлнэ. Дараах этгээд гэдэг нь:

- (a) Компанийн Гүйцэтгэх захирал, Ерөнхий санхүүч, Үйл ажиллагаа хариуцсан менежер, Компанийн томоохон хувьцаа эзэмшигч, Компанийн томоохон салбар;
- (b) Компанийн захирал, Компанийн томоохон хувьцаа эзэмшигч, Компанийн томоохон салбар;
- (c) Компанийн бизнесийн үндсэн нэгж, хэлтэс, үйл ажиллагааг хариуцсан этгээд эсвэл компани;
- (d) Компанийн томоохон хувьцаа эзэмшигч;
- (e) Компанийн үнэт цаасны хөрвүүлэлтийн дараах эзэмшил дээр тулгуурлан эзэмшиж буй томоохон хувьцаа эзэмшигч, үнэт цаасны хөрвүүлэлтийн дараах эзэмшил дээр тулгуурлан эзэмшиж буй томоохон хувьцаа эзэмшигчийн Гүйцэтгэх захирал, Ерөнхий санхүүч, Үйл ажиллагаа хариуцсан захирал;
- (f) Степ эсвэл Компанийн томоохон салбарт ач холбогдол бүхий менежмент, удирдлагын үйлчилгээ үзүүлдэг менежментийн компаниа, менежментийн компанийн бүх захирал, менежментийн компанийн Гүйцэтгэх захирал, Ерөнхий санхүүч, Үйл ажиллагаа хариуцсан захирал, ба менежментийн компанийн томоохон хувьцаа эзэмшигч нар;
- (g) Дээрх (a) – аас (f) догол мөрүүдэд тодорхойлогдсон Холбоотой этгээдүүдийн гүйцэтгэдэг ажил үүрэгтэй ижилхэн ажил үүрэг гүйцэтгэж буй хувь хүн;
- (h) Хэрэв өөрийн гаргасан Үнэт цаасыг худалдан авсан, буцаан авсан, эсвэл олж авсан бол тухайн үнэт цаасыг эзэмших тэр хугацаагаараа Степ өөрөө; эсвэл
- (i) Өөр бусад Холбоотой этгээдүүд, жишээлбэл:
  - (i) ажил үүргээ гүйцэтгэх явцдаа тухайн чухал баримт, чухал өөрчлөлтүүд нийтэд дэлгэгдэхээс өмнө Стептэй холбоотой чухал баримт, чухал

өөрчлөлтүүдийн талаарх мэдээллийг хүлээн авсан, эсвэл уг мэдээлэлд нэвтэрсэн Холбоотой этгээд; ба

- (ii) Компанийн бизнес, үйл ажиллагаа, хөрөнгө ба хөгжүүлэлтийн зохицуулах эрх мэдэл, нөлөөллийг, шууд болон шууд бусаар, хэрэгжүүлдэг, эсвэл хэрэгжүүлэх боломжтой Холбоотой этгээд..

**“Үнэт цаас”** гэдгийг *Онтариогийн Үнэт цаасны тухай хуулийн 1 (1)* дахь хэсэгт тодорхойлсон ба үүнд бүх хувьцаа, баталгаат эрхтэй опцион, хөрвөх чадвартай дээд ангиллын бонд, опцион, хориотой хувьцааны багц гэх мэт хөрвөх болон арилжих Үнэт цааснууд, Компанийн Үнэт цаасыг худалдах, худалдан авах бусад эрх, үүрэг, эсвэл бусад Үнэт цаас, Компанийн Үнэт цаасны зах зээлийн үнийг бодитоор өөрчлөх зах зээлийн үнэ зэрэг багтана.

**“Томоохон хувьцаа эзэмшигч”** гэдэг нь эзэмшлийн хувийг тооцоолох үүднээс үнэт цаасыг хуваарилах явцад андеррайтер байдлаар эзэмшдэг аливаа Үнэт цааснаас бусад үнэт цааг гаргагчийн бүхий л төлөгдөөгүй саналын эрхтэй Үнэт цааснуудад хамааралтай саналын эрхийн 10-аас дээш хувийг эзэмшдэг, шууд ба шууд бусаар үр ашиг хүртдэг, удирдан чиглүүлдэг этгээд, эсвэл компани;

Хэрэв аль нэг компани (1) өөр нэг компанийн удирдлага, хяналтанд байдаг, (2) өөр нэг компани болон түүнээс гадна нэг ба түүнээс олон тооны компаниудын удирдлага хяналтанд байдаг, (3) аль аль нь өөр нэг компанийн удирдлага хяналтад байдаг хоёр ба түүнээс дээш тооны компанийн удирдлага хяналтанд байдаг түүнийг өөр нэг компанийн **“Охин компани”** гэж үзнэ. Ерөнхийдөө, нэг компани нөгөө компанийнхаа саналын эрхтэй Үнэт цаасны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа үед эхний компани нөгөө компанийг удирдлага, хяналтандаа байлгана гэсэн үг.

Үнэт цаасны **“Арилжаа”** гэдэгт энэхүү Бодлогын дагуу аль нэг этгээдийн хувийн данс, эсвэл итгэмжлэлийн хувьд удирдан, чиглүүлэх бүхий л хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хамруулж болох ба түншлэл, итгэлцэл, гүйцэтгэх үүрэгтэй адил байна. Энэхүү Бодлогын гол зорилгын хүрээнд, арилжаа гэдэг нь аливаа үнэт цаасны худалдан, худалдан авах үйл ажиллагаа ба хөрөнгө оруулалтын зөвлөгөөг мөн багтаана.

**Хавсралт “В” / “Б”****ДОТООД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ, ЖИШЭЭ АГУУЛГА**

“Дотоод мэдээлэл” гэдэгт “бодит баримт” ба “чухал өөрчлөлт” аль аль нь багтана. Канадын жишээгээр бол, “бодит баримт” гэдэг нь Компанийн үнэт цаасны зах зээлийн үнэ ба үнэлгээнд томоохон нөлөөг бодитойгоор үзүүлж болох аливаа баримт юм. Харин “чухал өөрчлөлт” гэдэг нь Компанийн үнэт цаасны зах зээлийн үнэ ба үнэлгээнд томоохон нөлөөг бодитойгоор үзүүлж болох Компанийн бизнес, үйл ажиллагаа, капитал хөрөнгөнд гарсан аливаа өөрчлөлтийг хэлэх бөгөөд хэрэв Төлөөлөн удирдах зөвлөлөөс, эсвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг батлах боломжтой юм хэмээн үзсэн удирдах шатны албан тушаалтнууд тухайн өөрчлөлтийг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан бол уг шийдвэр мөн адил багтана.

Дотоод мэдээллийн бүх ангиллыг тодорхойлох боломжгүй. Гэхдээ хэрэв аль нэг хөрөнгө оруулагчид Компанийн нэт цаасыг худалдах, худалдан авах тухай шийдвэр гаргахад нь чухалд тооцогдох үндэслэлтэй магадлал буй бол уг мэдээллийг чухал хэмээн үзнэ.

Нөхцөл байдлаас хамаарч дараах мэдээллүүд дотоод мэдээлэлд тооцогдож болно. Үүнд:

- (a) санхүүгийн үр дүн;
- (b) Ирээдүйн ашиг, алдагдлыг таамаглал;
- (c) шинэ бүтээгдэхүүний хөгжүүлэлт, Компанийн нөөц бололцоо, технологи, бүтээгдэхүүн, зах зээлд нөлөөлөх хөгжүүлэлтүүд;
- (d) чухал нэгдэл үүсгэх, хамтарсан компаниа байгуулах тухай мэдээ;
- (e) томоохон хөрөнгийг захиран зарцуулах тухай, эсвэл аль нэг салбартай холбоотой мэдээлэл;
- (f) ашигт малтмалын нөөц ихсэх, багасах ба нөөцийн ангиллыг дахин тогтоох;
- (g) томоохон хайгуулын үр дүн;
- (h) хүлээгдэж буй дампуурал, санхүүгийн бусад асуудал;
- (i) үйлдвэрлэлд нөлөөлөх томоохон ажил тасалдалт болон бусад үйл явдал;
- (j) үнэд нөлөөлж болох аливаа өөрчлөлт ба гэрээ хэлцэл;
- (k) томоохон гүйцэтгэгч, нийлүүлэгч нартай томоохон хөдөлмөрийн маргаан, үл ойлголцол үүсэх;
- (l) хувьцаа хуваах гэх мэт хөрөнгийн бүтцэд өөрчлөлт оруулах төлөвлөгөө;
- (m) чухал санхүүжилт хүлээгдэх;

- (n) Үнэт цаасны төлөгдөөгүй дүн болон өр төлбөрийн дүн нэлээд их нэмэгдэх, эсвэл хасагдах;
- (o) Компанийн бизнест томоохон өөрчлөлт гарах;
- (p) Компанийн аудиторууд өөрчлөгдөх;
- (q) ач холбогдол бүхий гэрээний үүргийг зөрчих тохиолдол;
- (r) үнэт цаас эзэмшигчдийн саналд асуудал оруулсны үр дүн;
- (s) захирлууд, албан тушаалтнууд болон үнэт цаас эзэмшигчидтэй томоохон хэлцэл хийх;
- (t) бодит эсвэл болзошгүй заргатай холбоотой томоохон асуудал үүсэх;
- (u) өр төлбөр ба авлагатай холбоотой гүйлгээ нь Компанийн нэгтгэсэн хөрөнгийн үнэ цэнийн ихээхэн хэсгийг эзлэх;
- (v) Степээс ногдол ашиг олгох тухай санал, мэдэгдэл;
- (w) Степээс ногдол ашиг олгохгүй тухай санал, мэдэгдэл гаргах;
- (x) Компанийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого өөрчлөгдөх; ба
- (y) удирдлагын бүтцэд өөрчлөлт орох.

Эерэг, сөрөг мэдээллийн аль аль нь чухал байж болно.



Хавсралт “С” / “В”

**ХУВИЙН БА НУУЦЛАЛТАЙ МЭДЭЭЛЭЛ**

**ХЭНД: СТЕП ГОЛД ХХК (“КОМПАНИ” ГЭХ) БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН ЗАХИРЛУУД,  
АЛБАН ТУШААЛТНУУД БА АЖИЛЧДАД**

**УТГА НЬ: ХЭЛЦЛИЙН МЭДЭГДЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ НЬ**

Манай Үнэт цаасны арилжааны бодлогын дагуу, дараачийн мэдэгдэл гаргах хүртэл Компанийн цаашдын бүхий л үнэт цаас болон холбогдох санхүүгийн хэрэгслүүдийн хэлцлүүдийг түдгэлзэж өгнө үү.

Асууж тодруулах зүйл байвал [утасны дугаар], [цахим шуудангийн хаяг] –аар [ХЯНАЛТЫН АЛБАН ТУШААЛТАН] –тай холбогдоно үү.

Хүндэтгэсэн,

**СТЕП ГОЛД ХХК**